ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДГА-2025/168/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
“БАБИ ТАМИ АУДИТ” ХХК-ЫН
Захирал: З.Ундармаа
Ахлах аудитор: Т.Золбоо
Аудитор: Б.Батчимэг

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.02.25 № 1-6/157

танай ____________ -ны № ______________ -т

ХАТАНБУЛАГ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Д.БАЯРЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлыг онцолсон хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд цалингийн зардлаас 22.0 сая төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, ариутгалын төлбөр болон программын лицензийн төлбөрийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас зарцуулж, батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

This PC: D/2025 onii ajil/A4 toot

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **691,214,148.63** | **678,756,570.69** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 549,677,096.16 | 308,210,554.62 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 549,677,096.16 | 308,210,554.62 |
| **3121** | **Төгрөг** | 549,677,096.16 | 308,210,554.62 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 549,677,096.16 | 308,210,554.62 |
| **33** | **АВЛАГА** | 13,552,999.00 | 199,819,662.86 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 483,000.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 13,069,999.00 | 199,819,662.86 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 13,069,999.00 | 199,819,662.86 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 127,984,053.47 | 170,726,353.21 |
| **351** | **Түүхий эд материал** | 113,808,299.97 | 146,342,680.71 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 71,105,426.27 | 82,063,328.87 |
| 35130 | Эм боох материал | 42,702,873.70 | 64,279,351.84 |
| **354** | **Хангамжийн материал** | 14,175,753.50 | 24,383,672.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,504,260.00 | 2,967,780.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,778,238.00 | 3,266,617.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 8,577,400.00 | 17,412,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 315,855.50 | 737,275.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **675,949,738.98** | **3,275,412,325.69** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 675,949,738.98 | 3,275,412,325.69 |
| **392** | **Биет хөрөнгө** | 662,231,822.02 | 3,261,838,325.69 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 421,366,806.00 | 3,126,432,555.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (65,690,444.13) | (142,470,902.34) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 62,500,000.00 | 93,150,100.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (20,058,333.43) | (45,329,208.47) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 286,490,181.29 | 289,974,407.99 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (86,792,591.89) | (122,761,420.84) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 46,947,158.30 | 56,653,297.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,293,185.24) | (20,749,165.98) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 48,941,526.94 | 45,165,486.94 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (18,179,295.82) | (18,226,824.31) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 13,717,916.96 | 13,574,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,727,000.00 | 1,727,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,583,083.04) | (1,727,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,574,000.00 | 13,574,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,367,163,887.61** | **3,954,168,896.38** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,367,163,887.61** | **3,954,168,896.38** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,367,163,887.61 | 3,954,168,896.38 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 213,920,175.80 | 213,920,175.80 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 969,866,410.22 | 3,556,871,418.99 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 969,866,410.22 | 969,866,410.22 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 2,587,005,008.77 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 183,377,301.59 | 183,377,301.59 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,367,163,887.61** | **3,954,168,896.38** |

### Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **906,180,071.75** | **3,801,031,072.65** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **141,936,203.88** | **2,780,934,778.19** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 141,936,203.88 | 2,780,934,778.19 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 105,006,853.50 | 6,695,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 67,470,008.00 | 6,695,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 37,536,845.50 | 2,750,694,903.60 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 36,929,350.38 | 23,544,874.59 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **764,243,867.87** | **1,020,096,294.46** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 29,302,252.44 | 51,159,421.85 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 29,302,252.44 | 51,159,421.85 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 734,941,615.43 | 968,936,872.61 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 734,941,615.43 | 968,936,872.61 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **742,875,679.89** | **1,213,396,941.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **742,875,679.89** | **1,213,396,941.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 738,125,679.89 | 1,211,296,941.75 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 408,120,976.55 | 729,380,052.59 |
| 210101 | Үндсэн цалин | 210,369,317.47 | 421,474,353.57 |
| 210102 | Нэмэгдэл | 177,244,596.33 | 241,330,371.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,127,645.00 | 18,618,000.00 |
| 210104 | Урамшуулал | 16,379,417.75 | 47,957,327.59 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52,417,770.61 | 68,767,884.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,751,577.95 | 46,091,002.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,206,067.36 | 5,439,652.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,495,204.27 | 3,982,718.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 813,992.32 | 2,650,902.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,150,928.71 | 10,603,608.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,476,050.41 | 48,621,521.85 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,581,032.41 | 10,079,855.64 |
| 210302 | Түлш, халаалт | 21,432,378.00 | 33,934,498.21 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,462,640.00 | 4,607,168.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 61,013,445.00 | 70,518,851.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,265,180.00 | 2,900,880.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,442,909.00 | 51,666,240.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,660,000.00 | 2,460,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 828,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 14,817,356.00 | 13,371,731.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 97,684,280.04 | 79,099,988.65 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 91,606,863.04 | 68,304,936.65 |
| 210502 | Хоол, хүнс | 6,077,417.00 | 10,795,052.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,106,400.00 | 9,011,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,106,400.00 | 9,011,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,118,000.00 | 11,930,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,118,000.00 | 11,930,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,319,058.00 | 29,942,848.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,109,880.00 | 28,606,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,746,000.00 | 864,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 198,750.00 | 233,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 126,500.00 | 146,410.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 101,178.00 | 75,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 22,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 14,750.00 | 17,288.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 58,869,699.28 | 164,024,194.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 330,000.00 | 100,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 58,539,699.28 | 163,924,194.76 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,750,000.00 | 2,100,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,750,000.00 | 2,100,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,750,000.00 | 2,100,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **163,304,391.86** | **2,587,634,130.90** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 629,122.13 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 629,122.13 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (629,122.13) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **163,304,391.86** | **2,587,005,008.77** |

## Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **818,659,751.87** | **840,025,755.60** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **67,470,008.00** | **6,695,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 67,470,008.00 | 6,695,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 67,470,008.00 | 6,695,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 67,470,008.00 | 6,695,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **751,189,743.87** | **833,330,755.60** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 29,302,252.44 | 51,159,421.85 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 29,302,252.44 | 51,159,421.85 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 721,887,491.43 | 782,171,333.75 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 721,887,491.43 | 782,171,333.75 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **665,581,489.57** | **1,068,171,297.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **665,581,489.57** | **1,068,171,297.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **660,831,489.57** | **1,066,071,297.14** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 408,603,976.55 | 728,881,177.59 |
| 210101 | Үндсэн цалин | 210,671,962.47 | 420,975,478.57 |
| 210102 | Нэмэгдэл | 177,244,596.33 | 241,330,371.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,308,000.00 | 18,618,000.00 |
| 210104 | Урамшуулал | 16,379,417.75 | 47,957,327.59 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52,417,770.61 | 68,767,884.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,751,577.95 | 46,091,002.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,206,067.36 | 5,439,652.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,495,204.27 | 3,982,718.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 813,992.32 | 2,650,902.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,150,928.71 | 10,603,608.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,476,050.41 | 48,621,521.85 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,581,032.41 | 10,079,855.64 |
| 210302 | Түлш, халаалт | 21,432,378.00 | 33,934,498.21 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,462,640.00 | 4,607,168.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 57,378,918.00 | 79,474,627.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,311,800.00 | 3,432,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,338,909.00 | 59,539,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,660,000.00 | 3,920,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 150,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,263,309.00 | 190,687.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,654,900.00 | 12,391,440.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 56,893,746.00 | 83,002,480.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 41,450,566.00 | 71,546,430.80 |
| 210502 | Хоол, хүнс | 4,848,180.00 | 8,253,050.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,595,000.00 | 3,203,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 34,010,300.00 | 10,081,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 34,010,300.00 | 10,081,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,118,000.00 | 11,930,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,118,000.00 | 11,930,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,459,058.00 | 29,942,848.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,249,880.00 | 28,606,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,746,000.00 | 864,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 198,750.00 | 233,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 126,500.00 | 146,410.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 101,178.00 | 75,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 22,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 14,750.00 | 17,288.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,473,670.00 | 5,369,157.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,473,670.00 | 5,369,157.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,750,000.00** | **2,100,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,750,000.00 | 2,100,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,750,000.00 | 2,100,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **153,078,262.30** | **(228,145,541.54)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **147,883,905.00** | **13,321,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **147,883,905.00** | **13,321,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 147,883,905.00 | 13,321,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 129,263,905.00 | 11,872,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 18,620,000.00 | 1,449,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(147,883,905.00)** | **(13,321,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 5,194,357.30 | (241,466,541.54) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 549,677,096.16 |

| | | | |
|---|---|---|---|
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 549,677,096.16 | 308,210,554.62 |

## Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 213,920,175.80 | 183,377,301.59 | 821,656,218.36 | 1,218,953,695.75 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (15,094,200.00) | (15,094,200.00) |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **213,920,175.80** | **183,377,301.59** | **806,562,018.36** | 1,203,859,495.75 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 163,304,391.86 | 163,304,391.86 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **213,920,175.80** | **183,377,301.59** | **969,866,410.22** | 1,367,163,887.61 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **213,920,175.80** | **183,377,301.59** | **969,866,410.22** | 1,367,163,887.61 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **213,920,175.80** | **183,377,301.59** | **969,866,410.22** | 1,367,163,887.61 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 2,587,005,008.77 | 2,587,005,008.77 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **213,920,175.80** | **183,377,301.59** | **3,556,871,418.99** | 3,954,168,896.38 |

## Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,445,713,800.00 | 1,081,492,297.14 | 364,221,502.86 | 74.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,445,713,800.00 | 1,081,492,297.14 | 364,221,502.86 | 74.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,445,713,800.00 | 1,079,392,297.14 | 366,321,502.86 | 74.7 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 815,000,000.00 | 728,881,177.59 | 86,118,822.41 | 89.4 |
| 210101 | Үндсэн цалин | 480,000,000.00 | 420,975,478.57 | 59,024,521.43 | 87.7 |
| 210102 | Нэмэгдэл | 233,000,000.00 | 241,330,371.43 | (8,330,371.43) | 103.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 27,000,000.00 | 18,618,000.00 | 8,382,000.00 | 69.0 |
| 210104 | Урамшуулал | 75,000,000.00 | 47,957,327.59 | 27,042,672.41 | 63.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 94,418,200.00 | 68,767,884.90 | 25,650,315.10 | 72.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 64,258,200.00 | 46,091,002.55 | 18,167,197.45 | 71.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,540,000.00 | 5,439,652.75 | 2,100,347.25 | 72.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,770,000.00 | 3,982,718.80 | (212,718.80) | 105.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,770,000.00 | 2,650,902.20 | 1,119,097.80 | 70.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,080,000.00 | 10,603,608.60 | 4,476,391.40 | 70.3 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 77,944,000.00 | 48,621,521.85 | 29,322,478.15 | 62.4 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,000,000.00 | 10,079,855.64 | 920,144.36 | 91.6 |
| 210302 | Түлш, халаалт | 62,104,000.00 | 33,934,498.21 | 28,169,501.79 | 54.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,840,000.00 | 4,607,168.00 | 232,832.00 | 95.2 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 140,969,000.00 | 79,474,627.00 | 61,494,373.00 | 56.4 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,340,000.00 | 3,432,900.00 | 6,907,100.00 | 33.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 84,000,000.00 | 59,539,600.00 | 24,460,400.00 | 70.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,340,000.00 | 3,920,000.00 | 6,420,000.00 | 37.9 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,439,000.00 | 190,687.00 | 10,248,313.00 | 1.8 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,850,000.00 | 12,391,440.00 | 13,458,560.00 | 47.9 |
| **2105** | **Нормативт зардал** | 133,359,400.00 | 83,002,480.80 | 50,356,919.20 | 62.2 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 110,087,100.00 | 71,546,430.80 | 38,540,669.20 | 65.0 |
| 210502 | Хоол, хүнс | 8,272,000.00 | 8,253,050.00 | 18,950.00 | 99.8 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 15,000,300.00 | 3,203,000.00 | 11,797,300.00 | 21.4 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 96,500,000.00 | 23,402,600.00 | 73,097,400.00 | 24.3 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 45,000,000.00 | 11,872,000.00 | 33,128,000.00 | 26.4 |
| 210602 | Тавилга | 19,500,000.00 | 1,449,000.00 | 18,051,000.00 | 7.4 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,500,000.00 | - | 4,500,000.00 | 0.0 |
| 210604 | Урсгал засвар | 27,500,000.00 | 10,081,600.00 | 17,418,400.00 | 36.7 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 14,000,000.00 | 11,930,000.00 | 2,070,000.00 | 85.2 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,000,000.00 | 11,930,000.00 | 2,070,000.00 | 85.2 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 42,523,500.00 | 29,942,848.00 | 12,580,652.00 | 70.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,000,000.00 | 28,606,000.00 | 6,394,000.00 | 81.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,034,000.00 | 864,000.00 | 170,000.00 | 83.6 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,458,600.00 | 233,250.00 | 4,225,350.00 | 5.2 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,000,000.00 | 146,410.00 | 853,590.00 | 14.6 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 916,400.00 | 75,900.00 | 840,500.00 | 8.3 |
| 210807 | Газрын төлбөр | 114,500.00 | 17,288.00 | 97,212.00 | 15.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,999,700.00 | 5,369,157.00 | 25,630,543.00 | 17.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,999,700.00 | 5,369,157.00 | 25,630,543.00 | 17.3 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 2,100,000.00 | (2,100,000.00) | 0.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 2,100,000.00 | (2,100,000.00) | 0.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 2,100,000.00 | (2,100,000.00) | 0.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,445,713,800.00 | 840,025,755.60 | 605,688,044.40 | 58.1 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 82,944,000.00 | 51,159,421.85 | 31,784,578.15 | 61.7 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 82,944,000.00 | 51,159,421.85 | 31,784,578.15 | 61.7 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 813,807,200.00 | 782,171,333.75 | 31,635,866.25 | 96.1 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 813,807,200.00 | 782,171,333.75 | 31,635,866.25 | 96.1 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 548,962,600.00 | 6,695,000.00 | 542,267,600.00 | 1.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,650,000.00 | 6,695,000.00 | (5,045,000.00) | 405.8 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 547,312,600.00 | - | 547,312,600.00 | 0.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **549,677,096.16** | (549,677,096.16) | 0.0 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **308,210,554.62** | (308,210,554.62) | 0.0 |

## 5.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 412.5 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 2 алдааг залруулав.

### 5.1 Залруулсан алдаа

1. *Тайлант хугацаанд шинээр ашиглалтад орсон барилга байгууламж болох ханги хилийн боомт дахь ЭМТ-ийн барилга, худгийн усан хангамж, төмөр хашаа зэргийг ашиглалтын хугацааг 5 жилээр оруулж тайлант хугацааны элэгдлийн зардлыг нэмэгдүүлснийг залруулав.*
2. *Тайлант хугацаанд 4.8 сая төгрөгийн гэрэл цахилгааны зардлыг түлш халаалт, цэвэр бохир усны зардлаас шилжүүлсэн ба үр дүнгийн тайланд жинхэнэ зарлагаар тайлагнаагүйг залруулав.*

### 5.2 Албан шаардлага

<u>Зориулалт бус зарцуулалттай холбоотой</u>

Тус байгууллага нь тайлант хугацаанд цалингийн зардлаас 22.0 сая төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, ариутгалын төлбөр болон программын лицензийн төлбөрийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас зарцуулж, батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг буруу оруулснаас элэгдлийн зардлыг илүү тооцсон | 1 | 384,837.6 | - | - | 1 | 384,837.6 | 1 | 384,837.6 | | | | |
| Зардал буруу тайлагнасан | 1 | 4,801.3 | - | - | 1 | 4,801.3 | 1 | 4,801.3 | | | | |
| **Дүн** | **2** | **389,638.9** | **-** | **-** | **2** | **389,638.9** | **2** | **389,638.9** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Зардлыг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 22,911.8 | | | 1 | 22,911.8 | - | - | | | | |
| **Дүн** | **1** | **22,911.8** | | | **1** | **22,911.8** | **-** | **-** | | | | |